БАТЛАВ.
Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын дэд дарга, Төслийн захирал У.БЯМБАСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ
НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ИНСТИТУЦИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ НЬ ТӨСӨЛ

ТӨСЛИЙН БАРИМТ БИЧИГТ ЗААСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОРОН НУТГИЙН БҮХ ШАТНЫ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЧАДАВХЖУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЖ, ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр

Төслийн нэр:	“Монгол Улсад төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2-р үе шат
Төслийн дугаар:	7 F-09639.02.01
Дэд төслийн нэр:	“Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх нь”
Дэд төслийн дугаар:	81070200
Зөвлөх үйлчилгээний нэр:	Төслийн баримт бичигт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд Орон нутгийн бүх шатны хурлын үйл ажиллагааг чадавхжуулахад дэмжлэг үзүүлж, хэрэгжилт хариуцсан зөвлөх үйлчилгээ
Захиалагч :	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Швейцарын хөгжлийн агентлагийн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөл
Гэрээний төрөл:	Зөвлөх үйлчилгээний гэрээ
Гэрээний хугацаа:	2023 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал

ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Швейцарын хөгжлийн агентлагийн хамтарсан “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн зорилго нь шинэ батлагдсан орон нутгийн засаглалтай холбоотой Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуулиудын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаа, хяналтын болон хариуцан тайлагнах чадавхыг бэхжүүлэх замаар орон нутаг дахь төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах явдал юм.

ЗОРИЛГО

Энэхүү Ажлын даалгаврын зорилго нь орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Төлөөлөгч, Ажлын албадын чадавхыг бэхжүүлэх, сургалтын хөтөлбөр болон чадавхжуулах санхүүгийн механизмыг төгөлдөржүүлэхэд оршино. Мөн, бэлчээрийн тогтвортой менежментийг удирдах, хяналт тавих ИТХ-ын чадавх бэхэжсэн байна.

АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ: Төслийн үндсэн зорилгод хүрэхийн тулд төслийн баримт бичигт заагдсан үндсэн үйл ажиллагааны үр дүнгүүдэд хүрэх чиглэлээр Төслийн захирлын баталсан төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудад нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллана.

1. Төслийн тухайн жилийн төлөвлөгөөний Үр дүн-2 хүрэхэд чиглэсэн ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах (зөвлөх, ажил гүйцэтгэх г.м) гэрээнүүдийн ажлын даалгаврыг бэлтгэх.

2. Дээрх гэрээнүүдээр хийгдсэн ажлыг хянаж, хүлээн авахад Төслийн зохицуулагчид туслан Гэрээ дүгнэх, Бараа хүлээн авах маягтуудыг бэлтгэж ажиллана.

3. Төслийн төлөвлөгөөний Үр дүн-2 заасан ажлуудыг гүйцэтгэхэд чиглэсэн зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын арга хэмжээг зохион байгуулахад Төслийн зохицуулагчид мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн тухайн арга хэмжээний удирдамж, хөтөлбөрийг боловсруулж ажиллах.

4. Хариуцсан Үр дүнд хүрэхэд чиглэсэн зөвлөгөөн, хэлэлцүүлэг, сургалтын арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж Төслийн дотоод журмын Арга хэмжээний гүйцэтгэл гаргах журмын дагуу тайлан бэлтгэж ажиллах.

5. Төслийн баримт бичгийн Үр дүн 2-ын хүрээнд:
   5.1. Орон нутгаас сонгогдсон төлөөлөгчдөд зориулсан сургалтын хөтөлбөрийн санхүүжилтийн тогтвортой механизмыг үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэх ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
   5.1.1. ИТХ-ын сургалтын үндэсний хөтөлбөр, агуулга, гарын авлага боловсруулах, энэ чиглэлээр хэлэлцүүлэг өрнүүлэх ажлыг зохион байгуулж холбогдох гэрээний төсөл, удирдамж, хөтөлбөрийг боловсруулах
   5.1.2. Орон нутгийн засаглалын загвар сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хуулийн сургуулиудад нэвтрүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

   5.2. Үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулалтын чадавхыг сайжруулах замаар ИТХ-ын гүйцэтгэлийг сайжруулах ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах
   5.2.1. ИТХ-ын Төлөөлөгч, Нарийн бичгийн дарга нарт зориулсан (төрийн санхүүгийн менежмент, бэлчээрийн тогтвортой менежмент г.м) сургалтын хөтөлбөр боловсруулж www.khural.mn цахим хуудаст байршуулах
   5.2.2. ИТХ-тай холбоотой ЗГ-ын бодлого, (Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого г.м) чиглэлийг сурталчлах сургалт, хэлэлцүүлэг зохиох, удирдамж, хөтөлбөрийг боловсруулах

5.2.3. ИТХ-ын ажилтнуудыг ажил үүргээ гүйцэтгэх, орон нутгийн төлөө ажиллах чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч явах

5.3. Бэлчээрийн тогтвортой менежментийг удирдах, хяналт тавих тал дээр ИТХ-ын чадавхыг бэхжүүлэх ажилд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

5.3.1. Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид, иргэдэд Бэлчээрийн тогтвортой менежентийг сайжруулах талаар сургалт, хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

6. АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА:

6.1. Ажил гүйцэтгэх гэрээт ажлын хугацаа нь 2023 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуустал.

6.2. Гэрээт хугацаанаас хойш Зөвлөх нь гүйцэтгэсэн ажлынхаа чанарыг хариуцах үүргийн хүрээнд судалгааны дүнг албаны хүмүүс болон олон нийтэд танилцуулах, хэлэлцүүлэх бүхий л үйл ажиллагаанд оролцоно.

7. ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ТАВИХ

7.1. Талууд гэрээ байгуулахын өмнө энэхүү Ажлын даалгаварт тусгасан ажил, үйлчилгээний талаар ойлголтоо нэгтгэсэн байна.

7.2. Талууд гэрээ байгуулсны дараа Зөвлөх нь төлөвлөгөө боловсруулж Захиалагчтай зөвшилцсөний үндсэн дээр ажлаа эхлүүлнэ.

7.3. Гэрээний явц, хэрэгжилтийн талаар Захиалагч талд тогтмол мэдээлж, санал солилцон, хуваарийн дагуу тайлагнаж ажиллана.

Ажлын даалгаврыг боловсруулсан:

Төслийн захиргаа, санхүүгийн ажилтан:

Л.БАТЦЭЦЭГ

Нийт **3** хуудасны **3**-р хуудас